



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/945

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 159 дугаар тогтоолоор баталсан “Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалт MNTR 1:2008”, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А/84 тушаалаар баталсан “Согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд хяналт тавих журам”, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2022 оны 02/07 тоот хяналт шалгалтын удирдамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундааны үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт ирүүлсэн Мандалговь-Хүнс ХХК-ны холбогдох бичиг баримт, бүртгэл хөтлөлтүүдийг шалгах, үйлдвэрлэлийн орчинд хэмжилт хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Э.Мөнхзул	(Аймгийн ЗДТГ-ын худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)
Гишүүд: Н.Мөнгөнцэцэг	(Мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)
Б.Түвшинтөгс	(Мэргэжлийн хяналтын газрын хүнсний чанар стандартын хяналтын улсын байцаагч)
Ц.Доржпүрэв	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч)
Д.Энхтуяа	(Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн салбарын тэргүүн)
Б.Цэрэнханд	(Хүнс хөдөө аж ахуйн газрын үйлдвэр, худалдаа үйлчилгээний албаны дарга)
Х.Ганболд	(Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга)
М.Туяацэцэг	(Татварын хэлтсийн дарга)

2. Мандалговь-Хүнс ХХК-ны согтууруулах ундаа үйлдвэрлэх үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу хяналт шалгалтыг

4822100610

зохион явуулж дүгнэлтийг гаргаж хүргүүлэхийг ажлын хэсэг (Э.Мөнхзул)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ